

**АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ**

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС
РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛЭХ СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД
ХЯНАЛТ ТАВИХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БОЛОН ХЯНАЛТ, МОНИТОРИНГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН**

2024.10.18-ны өдөр

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.22-т заасан чиг үүргийн хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа радио, телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй нийт **119 телевиз, 56 радиогийн хөтөлбөрт** хуульд заасан үзүүлэлтээр хяналт, мониторинг хийх техникийн боломжийг бүрдүүлж ажиллалаа. Дээрх **175** радио, телевизээс Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.9-д заасны дагуу сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх хүсэлт, мэдэгдлийг нийт **69** телевиз, **34** радио ирүүлж, *(Радио телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх хяналт тавих журмын 2.4-т заасны дагуу МУИХ-ын сонгуулиар бүртгүүлсэн радио телевизийн хувьд сурталчилгаа нэвтрүүлэх цагийн хуваариа ирүүлж бүртгүүлсэн)* сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сурталчилгааны хугацаанд МҮОНРТ-ийн үндсэн сувгаас гадна сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн эрх бүхий **69** телевизээс нийт **42** телевиз нь сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байна.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд буюу 2024.09.26-10.09-ний өдрүүдэд телевизүүдээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн байдал:

Хүснэгт 1. Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн телевизийн тоо

Тусгай зөвшөөрлийн ангилал	Тусгай зөвшөөрлийн тоо/	Сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий радио, телевизүүд	Сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевиз		
	Хяналтад тоо		09.26-10.02	10.03-09	Нийт
Өргөн нэвтрүүлгийн телевиз	18/18	16	14+MNB	13+MNB	16+MNB
Арилжааны телевиз	53/50	18	5	6	7
Орон нутгийн телевиз	48/42	35	13	11	19
Радио -УБ	31/31	17	Гомдол гарвал бичлэгээс хуулж мониторинг хийхээр төлөвлөсөн		
Радио - Орон нутаг	31/25	17			

Нийт	175*	103	Нийт сурталчилгаа нэвтрүүлсэн радио, телевизийн тоо
			42 телевиз

*МҮОНРТ-ийн Телевизийн 5 суваг, радиогийн 4 суваг дээрх тоонд ороогүй хэдий ч Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан үзүүлэлтээр мөн хяналт тавьж ажилласан.


1. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙД:

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн **42** телевиз болон МҮОНТ-ээр нийт **137:22:29** цагийн нам, эвсэл, нэр дэвшигчид хамаарах сурталчилгаа нэвтрүүлснээс **132:27:50** цагийн сурталчилгааны нэвтрүүлэг, **5:04:37** цагийн богино хэмжээний сурталчилгаа, шторк нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 2. Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны цаг

№	огноо	ТВ-ийн тоо	Нэвтрүүлэг (сек)	Реклам (сек)	Нийт (сек)
1	2024.09.26	14 (10 ӨНТВ, АрТВ)	1:30:51	0:22:24	1:53:15
		8 Орон нутгийн ТВ	1:03:15	0:04:30	1:07:45
2	2024.09.27	14 (13 ӨНТВ, 1 АрТВ)	4:03:34	0:05:51	4:09:25
		7 Орон нутгийн ТВ	1:09:12	0:02:08	1:11:20
3	2024.09.28	14 (13 ӨНТВ, 1 АрТВ)	4:45:15	0:04:24	4:49:39
		5 Орон нутгийн ТВ	0:35:50	0:01:50	0:37:40
4	2024.09.29	15 (13 ӨНТВ, 2 АрТВ)	3:50:26	0:05:53	3:56:19
		9 Орон нутгийн ТВ	1:34:18	0:02:34	1:36:52
5	2024.09.30	15 (13 ӨНТВ, 2 АрТВ)	4:07:24	0:06:03	4:13:27
		12 Орон нутгийн ТВ	2:18:40	0:07:59	2:26:39
6	2024.10.01	15 (13 ӨНТВ, 2 АрТВ)	3:50:11	0:04:26	3:54:37
		10 Орон нутгийн ТВ	1:27:08	0:22:22	1:49:30
7	2024.10.02	14 (12 ӨНТВ, 2 АрТВ)	4:13:12	0:06:04	4:19:16
		11 Орон нутгийн ТВ	2:04:48	0:14:46	2:19:34
8	2024.10.03	13 (11 ӨНТВ, 2 АрТВ)	3:37:04	0:04:24	3:41:28
		11 Орон нутгийн ТВ	2:06:27	0:27:45	2:34:12
9	2024.10.04	14 (12 ӨНТВ, 2 АрТВ)	3:47:55	0:03:59	3:51:54
		9 Орон нутгийн ТВ	1:59:41	0:17:31	2:17:12
10	2024.10.05	15 (13 ӨНТВ, 2 АрТВ)	4:24:09	0:04:21	4:28:30
		11 Орон нутгийн ТВ	1:54:17	0:15:10	2:09:27
11	2024.10.06	15 (13 ӨНТВ, 2 АрТВ)	4:11:19	0:02:55	4:14:14
		9 Орон нутгийн ТВ	2:16:33	0:10:36	2:27:09
12	2024.10.07	15 (13 ӨНТВ, 2 АрТВ)	3:38:56	0:18:10	3:57:06
		10 Орон нутгийн ТВ	2:35:46	0:17:00	2:52:46
13	2024.10.08	16 (14 ӨНТВ, 2 АрТВ)	4:35:39	0:16:41	4:52:20
		12 Орон нутгийн ТВ	3:20:24	0:19:25	3:39:49


14	2024.10.09	14 (11 ӨНТВ, 3 АрТВ)	4:36:04	0:18:33	4:54:37
		7 Орон нутгийн ТВ	2:09:34	0:16:53	2:26:27
15	2024.09.26-10.09	MNB	50:30:00	0:00:00	50:30:00
	НИЙТ:		132:27:50	5:04:37	137:22:29




Телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааг төрлөөр нь авч үзэхэд **96.3** хувийг сурталчилгааны нэвтрүүлэг, **3.7** хувийг реклам тус тус эзэлж байна.

Телевизүүдээр сонгуулийн сурталчилгаа (шторк), сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байдлыг телевиз тус бүрээр гаргавал:

УБ хотын телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн цаг




УБ хотын телевизүүдээр сонгуулийн сурталчилгааны реклам нэвтрүүлсэн байдал




Телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн нэгдсэн дүнгээс харахад нам, эвслүүдээс сонгуулийн богино хэмжээний сурталчилгаа буюу реклам бага, харин сурталчилгааны хоногийн 15 минутдаа багтаасан сурталчилгааны нэвтрүүлгүүд илүү их нэвтрүүлсэн нь харагдаж байна. Сонгуулийн нийт сурталчилгааны хугацаанд Улаанбаатар хотын телевизүүд нийт **55:08:07** минутын нэвтрүүлэг, **1:47:05** минутын реклам гаргасан байна. Үүнээс Тэнгэр телевиз нь хамгийн их буюу **07:21:34** минутын нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол Мянгат малчин телевиз нь хамгийн их буюу **0:47:32** минутын реклам нэвтрүүлсэн үзүүлэлттэй байна. Түүнчлэн MNB нь батлагдсан хуваарийн дагуу нам, эсвэл, бие даагчдын 15 минутын сурталчилгааг **50:30:00** цаг нэвтрүүлсэн нь хамгийн өндөр цагийг эзлэж байна.

Орон нутгийн телевизүүдээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн цаг



Орон нутгийн телевизүүдээр сонгуулийн сурталчилгааны реклам нэвтрүүлсэн байдал



Орон нутгийн телевизүүдийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн цагийг хяналт, мониторингийн нэгдсэн дүнгээс харахад мөн нам, эвслүүдээс сонгуулийн богино хэмжээний сурталчилгаа буюу реклам бага, харин сурталчилгааны хоногийн 15 минутдаа багтаасан сурталчилгааны нэвтрүүлгүүд илүү их нийлүүлсэн нь харагдаж байна. Сонгуулийн нийт сурталчилгааны хугацаанд **26:49:43** минутын нэвтрүүлэг, **3:07:34** минутын реклам гаргасан ба үүнээс Орхон аймгийн Тусгал 1 телевиз нь хамгийн их буюу **03:02:16** минутын нэвтрүүлэг нэвтрүүлсэн, Дорнод аймгийн ТВ6 телевиз нь хамгийн их буюу **01:31:36** минутын реклам нэвтрүүлсэн үзүүлэлттэй байна.


3. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨР НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ.

Телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар нэвтрүүлсэн мэдээг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45.14-т заасны дагуу сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамааруулж тооцохгүй бөгөөд нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлэхгүй байх заалтыг зөрчсөн эсэх асуудлыг Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих, журмын 3.8-д заасны дагуу гомдлоор шийдвэрлэнэ гэж заасан. Зохицуулах хорооны зүгээс дээрх хуулийн 45.24-т заасны дагуу энэхүү хуульд заасан зөрчил гаргуулахгүй байх, гарсан зөрчлийг зогсоох арга хэмжээ авах чиг үүргийн дагуу радио, телевизээр нэвтрүүлсэн сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингоор нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн хэтрэлт бүртгэгдсэн эсэхийг хянаж, хэтрэлт гарсан тохиолдолд анхааруулж, зөвлөмж өгөх чиглэлээр ажиллахыг зорьсон бөгөөд мэдээний бүртгэлийн талаар тайлан мэдээндээ тусгаж ажилласан.

Хүснэгт 3. Телевизээр нэвтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээний цаг

№	Огноо	ТВ тоо	Нийт (цаг)	Мэдээний нэвтрүүлэгт гарсан	
				Нам, эвслийн тоо	бие даагчдын тоо
1	2024.09.26	УБ хотын 17 ТВ	2:24:51	3	0

		Орон нутгийн 5 ТВ	0:20:09	2	1
2	2024.09.27	УБ хотын 19 ТВ	3:03:07	5	0
		Орон нутгийн 7 ТВ	0:36:31	3	0
3	2024.09.28	УБ хотын 15 ТВ	2:08:29	2	0
		Орон нутгийн 3 ТВ	0:24:30	2	0
4	2024.09.29	УБ хотын 14 ТВ	1:52:41	3	0
		Орон нутгийн 1 ТВ	0:12:56	2	0
5	2024.09.30	УБ хотын 19 ТВ	2:32:14	3	0
		Орон нутгийн 1 ТВ	0:05:04	2	0
6	2024.10.01	УБ хотын 18 ТВ	2:48:39	4	0
		Орон нутгийн 3 ТВ	0:18:01	2	0
7	2024.10.02	УБ хотын 20 ТВ	3:17:59	3	0
		Орон нутгийн 4 ТВ	0:58:11	2	0
8	2024.10.03	УБ хотын 17 ТВ	2:30:14	4	0
		Орон нутгийн 3 ТВ	00:16:27	1	0
9	2024.10.04	УБ хотын 18 ТВ	1:46:50	5	0
		Орон нутгийн 3 ТВ	0:16:09	3	1
10	2024.10.05	УБ хотын 13 ТВ	1:30:46	3	0
		Орон нутгийн 1 ТВ	00:13:34	3	0
11	2024.10.06	УБ хотын 14 ТВ	1:18:53	4	0
		Орон нутгийн ТВ	0:00:00	-	-
12	2024.10.07	УБ хотын 16 ТВ	1:43:34	5	0
		Орон нутгийн 2 ТВ	00:06:39	1	0
13	2024.10.08	УБ хотын 20 ТВ	2:33:51	6	0
		Орон нутгийн ТВ	0:00:00	-	-
14	2024.10.09	УБ хотын 18 ТВ	2:05:02	5	0
		Орон нутгийн 5 ТВ	00:22:47	4	0
Нийт			34:41:38	86	2



4. СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛЭХ ЭРХГҮЙ РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН ЭСЭХ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.10-т “Энэ хуулийн 45.9-д заасны дагуу бүртгүүлсэн радио, телевиз сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхтэй бөгөөд бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэхийг хориглоно” гэж заасан байдаг.

Сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг Харилцаа холбооны зохицуулах хороонд хуульд заасан хугацаанд ирүүлж бүртгүүлээгүй буюу сонгуулийн сурталчилгаа явуулах эрхгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлсэн зөрчил бүртгэгдээгүй.

5. ТЕЛЕВИЗҮҮДИЙН ХӨТӨЛБӨРТ ХУУЛЬД ЗААСАН ЗӨРЧИЛ БҮРТГЭГДСЭН ЭСЭХ:

РАДИО, ТЕЛЕВИЗЭЭР НЭВТРҮҮЛСЭН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ДҮН.

Мониторингд хамрагдсан хугацаа: 2024.09.26-2024.10.11 өдрийг дуустал

Хүснэгт 4. Сонгуулийн сурталчилгааны хяналт, мониторингийн нэгдсэн дүн

№	Хяналт тавьсан үзүүлэлт	Улаанбаатар		Орон нутаг
		ӨН Телев из	Ар Телев из	Телевиз
1	Эх сурвалжийг дурдаагүй нэвтрүүлэг (Хуулийн 38.4)	-	-	-
2	Сурталчилгааг хоногт 1 цаг /60 минут/- аас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 45.6)	-	-	-
3	Нэг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сурталчилгааны хугацаа хоногт 15 минутаас хэтэрсэн эсэх: (Хуулийн 45.7)	1 ТВ	-	3 ТВ
4	Мэдээ: Нам, эвсэл, нэр дэвшигчийн мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх (Хуулийн 45.14)	11 ТВ	3 ТВ	1 ТВ
5	Нэр дэвшигч оролцсон энэ хуульд зааснаас бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн эсэх (Хуулийн 47.10)	9 ТВ	2 ТВ	8 ТВ
6	Сурталчилгааны бус нэвтрүүлэг, арилжааны сурталчилгаанд намын тэмдэг, уриа, далбаа, дүрс бичлэг, яриа орсон бол 3.6.1-3			-

Хуулийн үзүүлэлт тус бүрээр гаргасан хяналт, мониторингийн дүн мэдээ

5.1. Эх сурвалжийг дурдаагүй нэвтрүүлэг (Хуулийн 38.4) нэвтрүүлсэн эсэх;

Сонгуулийн сурталчилгааны аливаа материалын баруун доод хэсэгт сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэрийг тодорхой харагдахуйц байдлаар бичээгүй, эх сурвалжийг дурдаагүй сурталчилгааны нэвтрүүлэг гаргасан зөрчил телевизүүдэд бүртгэгдээгүй.

5.2. Сурталчилгааг хоногт 1 цаг /60 минут/-аас (Хуулийн 45.6) хэтрүүлсэн эсэх;

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны нийт хугацааны хяналт, мониторингийн дүн, мэдээгээр сонгуулийн сурталчилгааг хоногт 1 цаг /60 минут/-аас хэтрүүлсэн зөрчил бүртгэгдээгүй байна

5.3. Нэг, нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдэд хоногт ногдох сурталчилгааны 15 минутаас хэтрүүлсэн нь бүртгэгдсэн эсэх (Хуулийн 45.7);

Хүснэгт 5. Телевизээр нэвтрүүлсэн сурталчилгааны 15 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз	Тайлбар
1	09-р сарын 30-ны өдөр	Орон нутгийн 2 ТВ	Сайхан Монгол ТВ, Дорнод ТВ	Сайхан Монгол ТВ-ийн хувьд нэвтрүүлгийн давталт гаргасан бол Дорнод ТВ богино шторк нэмж гаргаснаар хэтрэлт болсон.
2	10-р сарын 03-ны өдөр	УБ 1ТВ	TenGer ТВ	Сурталчилгааны нэвтрүүлгийг давталт гаргаснаар хэтрэлт үүссэн
3	10-р сарын 06-ны өдөр	Орон нутгийн 1 ТВ	Дорнын ТВ6	Өмнөх өдрийн нэвтрүүлгийг давтсанаар хэтрэлт үүссэн.

- **Авсан арга хэмжээ:** Авсан арга хэмжээ: Дээрх 4 телевизүүдэд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45.24-т заасны дагуу эхний удаа утсаар сануулж, заавар, зөвөлгөө өгснөөр зөрчил дахин давтагдаагүй.

5.4. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаарх мэдээг хоногт 5 минутаас хэтрүүлсэн эсэх:

Хүснэгт 6. Мэдээний 5 минутын хэтрэлт бүртгэгдсэн байдал

№	Огноо	Хэтрэлт бүртгэгдсэн тоо	Хэтрэлт бүртгэгдсэн телевиз
1	09 сарын 26-ны өдөр	5	TV5, TV8, C1, NTV, Малчин
2	09 сарын 27-ны өдөр	6	25-р суваг, TV5, TV8, C1, NTV, Eagle

3	09 сарын 28-ны өдөр	4	25-р суваг, UBS, TV8, C1
4	09 сарын 29-ний өдөр	5	UBS, TV5, TV8, C1, Малчин
5	10 сарын 02-ны өдөр	10	25-р суваг, C1, TV9, NTV, TenGer, ETV, MNC, ONTV, News channel, Тусгал 1
6	10 сарын 03-ны өдөр	4	TV9, MNC, News channel, Тусгал 1
7	10 сарын 06-ны өдөр	1	ETV
8	10 сарын 08-ны өдөр	2	TV9, TenGer
9	10 сарын 09-ний өдөр	1	ETV

➤ **Авсан арга хэмжээ:** Нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ хоногт 5 минутаас хэтрэхгүй байх хуулийн 45.14 дэх заалтын тухайд: Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмын 3.8-д заасны дагуу хуулийн 45.14 дэх заалттай холбоотой гомдол, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтнаас гаргасан хүсэлтийн дагуу холбогдох баримт мэдээллийг хянан үзнэ гэж заасан тул хяналт, мониторингоор мэдээний хэтрэлт илэрсэн дээрх телевизүүдэд анхааруулж, зөвлөмж өгч ажилласан. Сонгуулийн сурталчилгааны хугацаанд нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээний хоногт гарах 5 минуттай холбоотой гомдол ирээгүй байна.

5.5. Нэр дэвшигч оролцсон сурталчилгааны бус нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлага (Хуулийн 47.10) нэвтрүүлсэн эсэх:

Сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс, бичлэг, ярилцлага нэвтрүүлэхийг хориглосон.

Хүснэгт 7. Телевизүүдээр нэр дэвшигч оролцсон, яриа өгсөн нэвтрүүлгийн бүртгэл

№	Огноо	Зөрчил бүртгэгдсэн тоо	Зөрчил бүртгэгдсэн телевиз
1	09-р сарын 26	7	MNB2, ТМ, С1, ETV, Хөгжим, Сайхан монгол ТВ, BBS ТВ
2	09-р сарын 27	5	ТМ ТВ, Баянхонгор ТВ, Сайхан Монгол ТВ, Хөгжим, Масс ТВ
3	09-р сарын 28	8	25-р суваг, MNB2, ТВ8, UBS Жаргалант ТВ, Сайхан Монгол, DBS, RGB
4	09-р сарын 29	4	С-1, ТВ-8, UBS, DBS
5	09-р сарын 30	1	Мэдээллийн бирж ТВ
6	10-р сарын 01	2	Мэдээллийн бирж ТВ, UCTV
7	10-р сарын 02	1	ТВ, UCTV,
8	10-р сарын 03	1	Жаргалант ТВ
9	10-р сарын 04	1	25-р суваг

10	10-р сарын 05	1	Ийгл ТВ
11	10-р сарын 06	1	ТВ9

➤ **Авсан арга хэмжээ:** Энэхүү тайлангийн 5.5 дахь хэсэг- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.10 дахь заалтад заасан нэр дэвшигч оролцсон энэ хуульд зөвшөөрснөөс бусад хэлбэрийн бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, ярилцлага нэвтрүүлсэн дээрх телевизүүдэд тухай бүр анхааруулга, зөвлөгөө өгч ажилласнаар дахин эфирт гаргаагүй, зөрчил давтагдаагүй байна.


6. МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛГИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн сурталчилгааны үеэр нийт 4 телевиз буюу MNB1, MNB мэдээ, 25-р суваг телевиз, TenGer телевизүүд нь нийт 122:58:30 цагийн 78 удаагийн мэтгэлцээний нэвтрүүлэг хийж нэвтрүүлсэн байна.

МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

№	Телевизийн нэр	Шинэ дугаар	Нийт нэвтрүүлсэн цаг	Дохионы хэлтэй нэвтрүүлсэн байдал
1	MNB	23	30:50:06	-
2	MNB-2	25	33:28:11	-
3	TenGer	26	51:15:55	Бүтэн
4	25-р суваг	4	7:24:18	-
	Нийт	78	122:58:30	

ТЕЛЕВИЗ ТУС БҮРИЙН МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭВТРҮҮЛГИЙН НИЙТ ЦАГТ ЭЗЛЭХ ХУВЬ



МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦОГЧИД НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААГЧИЙН ТООГООР


№	Нам, эвсэл, бие даагч	MNB	MNB2	25-р суваг	Тэнгэр	Нийт /нам, эвслээр/
1	Хөдөлмөрийн үндэсний нам	10	-	-	9	19
2	Ардчилсан нам	7	-	3	12	22
3	Монгол ардын нам	10	-	3	8	21
4	Иргэний зориг ногоон нам	6	-	-	6	12
5	Үндэсний эвсэл	5	-	-	7	12
6	Үнэн ба Зөв нам	4	-	-	1	5
7	Иргэдийн оролцооны нэгдэл нам	5	-	-	4	9
8	Сайн Ардчилсан Иргэдийн Нэгдсэн Нам	4	-	-	2	6
9	Ард түмний олонхийн засаглал нам	2	-	-	4	6
10	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	1	-	-	1	2
11	Бие даагч	1	-	-	-	1
Нийт		54	-	6	54	115

**MNB2 суваг нь MNB сувгаар гарсан мэтгэлцээнийг давтан гаргаж байсан тул шинэ оролцогчгүй болно.*

Сонгуулийн сурталчилгааны үед нам, эвсэл, бие даагч нарын нийт 115 төлөөлөл мэтгэлцээнд оролцсон ба MNB хамгийн их буюу 11 нам, эвсэл, бие даагчийг оролцуулсан бол Ардчилсан намаас хамгийн олон удаа мэтгэлцээнд оролцсон байна. Харин Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам хамгийн бага буюу 2 төлөөлөл мэтгэлцээнд оролцсон бол бие даан нэр дэвшигч нараас 3. Хүрэлбаатар Монголын Үндэсний олон нийтийн телевизээс зохион байгуулсан мэтгэлцээнд 1 удаа оролцсон байна.


МЭТГЭЛЦЭЭНД ОРОЛЦОГЧИД НАМ, ЭВСЛЭЭР

(телевиз тус бүрээр)



7. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН НЭВТРҮҮЛЭГ, СУРТАЛЧИЛГАА НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит сонгуулийн сурталчилгааны болон санал хураалтын өдөр буюу 2024 оны 09-р сарын 26-ны өдрөөс 10-р сарын 11-ний өдрийн хооронд Улаанбаатар хотын 16 телевизээр нийт 12:35:30 минутын нэвтрүүлэг, 19:29:15 минутын сурталчилгаа, орон нутгийн 12 телевизээр нийт 6:19:31 минутын нэвтрүүлэг, 29:44:26 минутын сурталчилгаа нэвтрүүлсэн байна.



**ТЕЛЕВИЗҮҮДИЙН СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН
НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ**

№	Телевизийн нэр	Нийт нэвтрүүлсэн тоо	Нийт нэвтрүүлгийн цаг	Дохионы хэлмэрчтэй нэвтрүүлгийн цаг	Бичгэн тайлбартай нэвтрүүлсэн цаг
Улаанбаатар хотын телевиз					
1	MNB Монголын мэдээ	1	0:18:54	-	-
2	Bloomberg MN	8	8:06:08	-	-
3	Ийгл ньус	4	1:54:13	-	-
4	Монгол HD	3	2:16:15	2:16:15	-
Орон нутгийн телевиз					
1	Дархан-Уул - RGB	12	1:03:58	-	-
2	Дорноговь - DTV	6	2:35:08	-	-
3	Орхон - EгTV	6	0:52:43	2	0:16:44
4	Архангай - Тамир	2	0:21:18	-	-
5	Ховд - Ховд	1	1:26:24	-	-
Нийт		43	18:55:01	2:16:15	0:16:44

Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгийн хувьд Блүүмбэрг ТВ хамгийн их буюу 8 удаа нийт 8:06:08 цагийн, Дархан-Уул аймгийн RGB телевиз 12 удаа нийт 1:03:58 минутын нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Түүнчлэн Монгол HD ТВ 3 удаа нийт 2:16:15 минут, Орхоны EгTV 2 удаа 0:16:44 минутын нэвтрүүлгийг **Дохионы хэлний хэлмэрчтэй** нэвтрүүлсэн байна.

**ТЕЛЕВИЗҮҮДИЙН СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН
СУРТАЛЧИЛГААНЫ ШТОРК НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ**

№	Телевизийн нэр	Нийт нэвтрүүлсэн тоо	Нийт нэвтрүүлгийн цаг	Дохионы хэлмэрчтэй нэвтрүүлгийн цаг	Бичгэн тайлбартай нэвтрүүлсэн цаг
Улаанбаатар хотын телевиз					
1	MNB	275	6:08:18	-	1:15:44
2	Тэнгэр ТВ	138	3:13:17	-	0:09:29
3	NTV	96	2:18:25	-	0:30:48

4	UBS	67	1:27:21	-	0:18:58
5	Суваг 1	63	1:31:25	-	0:10:38
6	ETB	59	1:18:19	-	0:17:47
7	Боловсрол суваг	45	0:17:34	-	-
8	Bloomberg MN	40	0:53:39	-	0:11:52
9	Гандан ТВ	31	0:35:35	-	0:08:17
10	ТМ	30	0:40:08	-	0:08:18
11	ТВ5	22	0:29:27	-	0:05:59
12	Ийгл ньюс	14	0:19:25	-	0:03:33
13	С1	5	0:07:33	0:01:33	0:01:12
14	Стар ТВ	5	0:08:49	-	-
Орон нутгийн телевиз					
1	Завхан - Air 1	483	9:49:01	0:00:00	4:46:14
2	Орхон - ErTV	269	7:26:20	3:44:17	5:25:24
3	Хэнтий - Өндөрхаан	141	5:45:50	5:45:50	5:45:50
4	Ховд - Олон ястан	71	1:38:51	0:59:48	1:09:49
5	Орхон - Тусгал 1	59	1:22:15	0:00:00	0:15:22
6	Баянхонгор - Номгон	52	1:24:39	0:00:00	0:13:01
7	Өмнөговь - UCTV	40	0:54:02	0:00:00	0:11:40
8	Дархан-Уул - RGB	32	0:46:34	0:00:00	0:26:41
9	Дорнод - Дорнод	25	0:36:54	0:15:34	0:30:20
Нийт		1172	29:44:26	10:45:29	18:44:21

Сонгогчдын боловсролд зориулсан сурталчилгааны хувьд MNB хамгийн их буюу 275 удаагийн 6:08:18 минут, Завхан аймгийн Air1 телевиз 483 удаагийн 9:49:01 минутын сурталчилгаа нэвтрүүлсэн бол Улаанбаатар хотын 12 телевиз, орон нутгийн 9 телевиз тус бүр хадмал тайлбартай нэвтрүүлсэн байна.

РАДИОГИЙН ХУВЬД: Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (АНСДИТХ)-ын сонгуулийн сурталчилгааны хугацаанд Улаанбаатар хотын 31 радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн эфирийн бичлэгийг хийж, хадгалсан. Тэдгээр радиогоос 17 радио АНСДИТХ-ын сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхээр бүртгүүлсэн ба дээрх хугацаанд буюу 2024 оны 09-р сарын 26-30-ны өдрүүдэд сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрх бүхий 7 радиогийн, 10-р сарын 01-11-ний өдрүүдэд үлдсэн нэр бүхий 10 радио тус бүрийн өдөр бүрийн хөтөлбөрийн протоколийг гомдол маргаантай холбоотойгоор гаргуулан авсан. Орон нутгийн радиогийн үйлчилгээ эрхлэгчдийн хөтөлбөрт АНСДИТХ-ын сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхтэй холбоотой гомдол, маргаан гарсан тохиолдолд тухайн гомдолтой холбоотойгоор хөтөлбөрт хяналт, мониторинг хийхээр төлөвлөж ажилласан.

Сонгуулийн сурталчилгааны хугацаанд радиогоор нэвтрүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх сурталчилгаа болон мэдээний хоногт гарах 5 минуттай холбоотой аливаа гомдол, хүсэлт одоогоор ирээгүй байна.

МҮОНТ-ИЙН МNВ СУВГААР ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ НЭВТРҮҮЛЭХ СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛГИЙН ТАЙЛАН

09-р сарын 26-10-р сарын 09-ний өдрүүд

МҮОНТ-ээр үнэ төлбөргүйгээр 10 нам, 1 эвсэл түүнчлэн бие даан нэр дэвшигчдийн нийт **357** удаагийн **59** цагийн нэвтрүүлэг нэвтрүүлэх хуваарь, цаг батлагдсан. Батлагдсан хуваарийн дагуу нэвтрүүлсэн байдалд хяналт, мониторинг хийлээ.


MNB сувгаар сонгуулийн сурталчилгааны нийт хугацаанд 10 нам, 1 эвсэл, бие даан нэр дэвшигчдийн нийт **303** удаагийн **50** цаг **30** минутын сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байна. Нийт батлагдсан хуваариас Монгол ардын нам-**15** удаа, Ардчилсан нам-**5** удаа, Хүн нам-**1** удаа, Ард түмний олонхийн засаглал нам-**1** удаа, Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам-**1** удаа мөн **30** бие даан нэр дэвшигчийн нэвтрүүлэг хуваарьт цагтаа гараагүй бол бусад бүх нэвтрүүлэг хуваарьт цагтаа эфирт гарчээ.

MNB СУВГААР НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛЭГ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

№	Нам, эвсэл, бие даагч	Хуваарь өдөр, цагтаа		Нийт нэвтрүүлгийн цаг
		гарсан	гараагүй	
1	Монгол ардын нам	74	15	12:20:00
2	Ардчилсан нам	83	6	13:50:00
3	Үндэсний эвсэл	19	-	03:10:00
4	Иргэний зориг ногоон нам	26	-	04:20:00
5	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	1	-	00:10:00
6	Иргэний хөдөлгөөний нам	37	-	06:10:00
7	Хүн нам	43	1	07:10:00
8	Үнэн ба зөв нам	5	-	00:50:00
9	Ард түмний олонхийн засаглал нам	1	1	00:10:00
10	Иргэдийн оролцооны нэгдэл нам	8	-	01:20:00
11	Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам	3	1	00:30:00
12	Бие даан нэр дэвшигчид	3	30	00:30:00
Нийт		303	54	50:30:00

MNB сувгаар сонгуулийн сурталчилгааны нийт хугацаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн нийт **303** удаагийн **50** цаг **30** минутын нэвтрүүлэг нэвтрүүлсний **03** цаг **10** минут нь дохионы хэлмэрчтэй, бичгэн тайлбартай нэвтрүүлэг байна.

Дохионы хэл, бичгэн тайлбартай нэвтрүүлгийн нийт нэвтрүүлэгт эзлэх хувь, цаг



НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААГЧИЙН СУРТАЛЧИЛГААНЫ НЭВТРҮҮЛГИЙН ДОХИОНЫ ХЭЛ, БИЧГЭН ТАЙЛБАРТАЙ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

№	Нам, эвсэл, бие даагч	Нийт нэвтрүүлгийн цаг	Дохионы хэлтэй	Бичгэн тайлбартай	Дохионы хэл, бичгэн тайлбаргүй нэвтрүүлгийн нийт цаг
1	Монгол ардын нам	12:20:00	-	-	12:20:00
2	Ардчилсан нам	13:50:00	02:22:26	-	08:06:13
3	Үндэсний эвсэл	03:10:00	00:09:57	-	01:39:58
4	Иргэний зориг ногоон нам	04:20:00	00:19:36	-	04:00:24
5	Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам	00:10:00	-	-	00:10:00
6	Иргэний хөдөлгөөний нам	06:10:00	-	-	06:10:00
7	Хүн нам	07:10:00	00:09:37	00:09:37	07:00:23
8	Үнэн ба зөв нам	00:50:00	-	-	00:50:00
9	Ард түмний олонхийн засаглал нам	00:10:00	-	-	00:10:00
10	Иргэдийн оролцооны нэгдэл нам	01:20:00	-	-	01:20:00
11	Сайн иргэдийн нэгдсэн нам	00:30:00	-	-	00:30:00
12	Бие даан нэр дэвшигчид	00:30:00	-	-	00:30:00
Нийт		50:30:00	03:01:36	00:09:37	42:46:58

Сонгуульд өрсөлдөгч нам, эвслүүдээс Ардчилсан нам нийт нэвтрүүлгийнхээ 17.16% орчмыг, Иргэний зориг ногоон нам 7.53% орчмыг, Үндэсний эвсэл нам 5.23% орчмыг, тус тус дохионы хэлмэрчтэй бэлтгэн нэвтрүүлжээ.